

СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, ЯПОН УЛСЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Япон Улсын Засгийн газрын урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийж буй Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг, Япон Улсын Ерөнхий сайд Абэ Шинзо нар 2013 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцээ хийж, хэлэлцээний дүнгээр энэхүү Хамтарсан мэдэгдлийг гаргав.

1. Ерөнхий сайд нар, Монгол, Японы харилцаа 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш дараах үе шатыг дамжин амжилттай хөгжиж ирсэнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв.

(1) Ерөнхий сайд нар, Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн 1990 –ээд оноос хойшхи хоёр улсын харилцаа нь хүний эрх, ардчилал, зах зээлийн эдийн засгийн нийтлэг үнэт зүйлст тулгуурлан тууштай өргөжин хөгжиж байгааг онцлон тэмдэглэв.

(2) Ерөнхий сайд нар, 2007 онд байгуулсан “Япон, Монголын хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр” нь хоёр талын хүчин чармайлтын үр дүнд хугацаанаасаа өмнө амжилттай хэрэгжсэнд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлээд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2010 онд Япон Улсад айлчлах үеэр тохиролцсон "Стратегийн түншлэл"-ийг цаашид бэхжүүлэх нь хоёр улсын гадаад бодлогын нийтлэг, шинэ зорилт болохыг нотлов.

(3) Ерөнхий сайд нар, Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ –ийн 2013 оны 3 дугаар сард Монгол Улсад айлчлах үеэрээ дэвшүүлсэн хоёр улсын харилцааны үндэс болох “эрх чөлөө ба ардчилал, энх тайван, харилцан туслалцах” гэсэн үзэл санааны ач холбогдолыг тэмдэглээд энэхүү үзэл санаанд тулгуурлан хоёр улсын харилцааг цаашид бэхжүүлэн хөгжүүлэхийн төлөөх хүсэл эрмэлзлэлээ дахин нотлохын зэрэгцээ энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтыг дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлэв. Мөн, Ерөнхий сайд Ш. Абэ-ийн дэвшүүлсэн хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх “Эрч” санаачилга амжилттай хэрэгжиж байгааг онцлон тэмдэглэв.

2. Ерөнхий сайд Н.Алтанхуягийн Япон Улсад хийж буй энэ удаагийн айлчлалын үеэр хоёр улсын стратегийн түншлэлийг улам бүр бэхжүүлэхэд чиглэсэн, харилцан ашигтай, бие биеэ нөхсөн хоёр талын харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх зорилт бүхий “Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-ийг байгуулав. Ерөнхий сайд нар энэхүү хөтөлбөрийг 2013-2017 онд хэрэгжүүлэхээр санал нэгдэв.

3. Хоёр улсын Засгийн газар “Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүднээс дараахи тодорхой зорилтуудыг хэрэгжүүлнэ:

(1) Улс төр, аюулгүй байдлын салбарт:

а. Олон талт, стратегийн ач холбогдол бүхий яриа хэлэлцээг өрнүүлж, улс төрийн итгэмжилсэн харилцааны өндөр түвшинг хадгалж, харилцан ойлголцол, харилцан итгэлцлийг бэхжүүлнэ,

б. Ази-Номхон далайн бүс нутаг болон дэлхий дахинд энх тайван, тогтвортой байдлыг ханган бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаагаа хөгжүүлнэ,

в. Нийтлэг үнэт зүйлс эрхэмлэдэг бүс нутгийн чухал түншүүд болохын хувьд бүс нутаг, олон улсын тавцанд харилцан дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлнэ.

(2) Эдийн засгийн салбарт:

а. “Эрч” санаачилгад тусгасан арга хэмжээнүүдийг бодитоор хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт бизнесийн орчинг сайжруулах, Монгол Улсын тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангах хамтын ажиллагааг гүнзгийрүүлж өргөжүүлнэ,

б. Хоёр улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтыг үсрэнгүй тэлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах зорилгоор "Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр"-ийн яриа хэлэлцээг эрчимжүүлж, ойрын хугацаанд эцэслэнэ.

(3) Соёл, иргэд солилцооны салбарт

Хоёр улсын ард иргэдийн харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, харилцан итгэлцлийг бэхжүүлэх үүднээс соёлын хамтын ажиллагааг тууштай хөгжүүлж, иргэд харилцан зорчих таатай орчинг бүрдүүлэн, хэлхээ холбоог өргөжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НОРОВЫН АЛТАНХУЯГ

ЯПОН УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
АБЭ ШИНЗО

Токио хот,
2013 оны 9 сарын 13 –ны өдөр